



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 1/179

Ховд

Г Жуух бичгээр шагнах тухай Т

Аймаг, нийслэлийн Засаг даргаас олгох шагналын тухай Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолын 1-ийн "Е", аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.8, 3.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 98 жилийн ойн баярыг тохиолдуулан Эх орон, ард түмнийхээ төлөө өргөсөн тангарагтаа үнэнч байж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэн Зэвсэгт хүчнийг бэхжүүлэх үйлсэд хамт олноо манлайлан олон жил үр бүтээлтэй ажиллаж буй Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар салбарын Зэвсэг, сум, галт хэрэгсэл, сэлбэгийн нярав, ахлах ахлагч Ч.Дагва, 332 дугаар салбарын Планшет тоотын захирагч, ахлах ахлагч Ж.Гэрэлчулуун нарыг аймгийн Засаг даргын "Жуух бичиг"-ээр шагнасугай.

2. Аймгийн Засаг даргын жуух бичгээр шагнагдсан Ч.Дагва, Ж.Гэрэлчулуун нарт 1 сарын хугацаанд үндсэн цалингийн 20 хувиар тооцож урамшуулал олгохыг Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305, 332 дугаар салбарын захирагч нар / хошууч Д.Батдаваа, Б.Баянжаргал нар/-т зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax A/179 Ch
02 00871